

Мэндчилгээ



Австралийн парламентийн гишүүн асан хатагтай Кирстен Ливермор АМЕП 2 хөтөлбөрийн удирдагчаар энэ оны 9 сард томилогдлоо. Тэрээр АМЕП 2 хөтөлбөр зорилго, зорилтдоо хүрэхэд багаа удирдан чиглүүлж, эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана.

“Уул уурхайн бүс нутгийн ард иргэдийг төлөөлөн Австралийн парламентад гурван удаа сонгогдсон, мөн Австралийн уул уурхайн зөвлөлийг удирдан ажиллаж байсан туршлага маань надад эрдэс баялгийн салбарт засгийн газар, компаниуд, мөн олон нийт ямар бэрхшээлтэй тулгардаг, нөгөөтэйгүүр ямар боломж бололцоо байдгийг бүх талаас нь харах боломж олгосон. Гадаадын хөрөнгө оруулалт татах, уул уурхайн салбарыг хэрхэн хариуцлагатай удирдах Австралийн туршлагыг хуваалцахаас гадна Монголчуудаас их зүйл сурна гэж найдаж байна” хэмээн хатагтай Ливермор хэлж байна.

Тэрээр 2019 оны 9 дүгээр сарын 27-нд болох “Дисковер Монголиа” хуралд илтгэл тавина.

АМЕП 2-ын товч танилцуулга

Байгалийн баялагт суурилсан Монгол улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор “Австрали Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийг (АМЕП, англи орчуулгын товчлол) Монгол, Австралийн Засгийн газар хамтран хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн эхний үе шатыг 2015-19 онд амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд 2019 оны 4 дүгээр сарын 1-нээс хөтөлбөрийн хамрах хүрээг өргөтгөн, илүү олон оролцогч талтайгаар хоёр дугаар шатыг эхлүүллээ. АМЕП 2-ын зорилго нь МУ-ын эдийн засгийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулах эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхэд оршино.

АМЕП 2 нь оролцогч талуудын хэрэгцээнд суурилан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жил бүр 12 сарын хугацаанд хэрэгжүүлэх төслүүдийн төлөвлөгөө гарган ажилладаг. АМЕП 2 эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалттай холбоотой төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг шийдэх санал санаачлагуудыг дэмжихийг зорьдог. Ингэхдээ олон талт хамтын ажиллагаа, зөвшилцөөн хэлцлийг түлхүү дэмжин ажиллана.

Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам (ГХХЯ) АМЕП 2-ыг санхүүжүүлж, Адам Смит Интернэшнл компани хэрэгжүүлж байна. Хөтөлбөр 2023 он хүртэл хэрэгжинэ.

2019-20 онд хэрэгжүүлэх төслүүд

АМЕП 2 хөтөлбөрийн баг 2019 оны 4, 5 дугаар сард засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын олон төлөөлөлтэй уулзаж зөвлөлдөн, салбарын тулгамдсан асуудлуудыг тодорхойлж, хэрэгжүүлж болох төсөл, үйл ажиллагаагаа тодорхойлсон юм. Оролцогч талуудынхаа үнэтэй санал зөвлөгөөнд үндэслэн, 2019-20 онд хэрэгжүүлэхээр эцэслэн тогтсон үйл ажиллагаанууд маань салбарт тулгардаг нийтлэг асуудлуудыг багтаасан, МУ-ын эрдэс баялгийн салбарын хөгжилд эерэг өөрчлөлт авчрах төслүүд гэж найдаж байна.

Австралийн ГХХЯ, Монгол улсын Сангийн яам 2019 оны 9 дүгээр сард АМЕП 2-ын жилийн төлөвлөгөөг баталсныг дуулгахад таатай байна. Бид 2019-20 онд нийт зургаан төсөл хэрэгжүүлэх бөгөөд түнш байгууллага, оролцогч талуудтайгаа хамтран, эдгээр төслөө амжилттай хэрэгжүүлж, бодит үр дүн гаргана гэдэгтэй итгэлтэй байна.

Үргэлжлэл т.2 ►►

**Танд асуулт
байна уу?**

АМЕП 2-ын үйл ажиллагаа, хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг www.amep.mn цахим хуудаснаас үзнэ үү. Мөн Хамтын ажиллагааны менежер П.Оюунбилэгтэй oyunbileg@amep.mn хаягаар холбогдож болно.

2019-20 онд хэрэгжүүлэх төслүүд

2019-20 онд хэрэгжүүлэхээр батлагдсан АМЕП 2-ын төслүүд:

1. Монголын ашиг малтмалын хөрөнгийн үнэлгээний код боловсруулах
2. Техник эдийн засгийн үнэлгээ боловсруулах журмыг шинэчлэхэд туслалцаа үзүүлэх
3. Татварын хуулинд заасан үнэ шилжилтийн тухай заалтуудыг хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх
4. Монгол Улсын геологийн мэдээллийн каталоги системд мэдээлэл оруулах ажилд туслалцаа үзүүлэх

5. Нүүрсний давхаргын метан хийн хууль эрх зүйн зохицуулалтын талаар дэмжлэг үзүүлэх, Австрали Улсын туршлагыг судлах

6. Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрэгжүүлэх удирдамжийг боловсруулах

Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд та бүхэнтэй хамтран ажиллахдаа бид таатай байх болно.

Хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бид цаг тухайд нь www.amep.mn цахим хуудсандаа байрлуулна.

Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын нийтлэг асуудалд шийдэл болохуйц, тэнцвэртэй хөтөлбөр, үйл ажиллагаа явуулахыг АМЕП 2 зорьдог. Мөн төсөл бүр МУ-ын эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэсэн байх ёстой гэсэн зарчим баримталдаг.

Төсөл бүр дараах шаардлагуудыг хангасан байна.

Шалгуур	Үнэлгээ
Хамаатай байх	Санал болгож буй төсөл нь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах гэсэн АМЕП 2-ын зорилгод нийцэж байгаа эсэх
Тодорхой, ойлгомжтой байх	Санал болгож буй төслийн үр дүн хэзээ гарах, тоон болон чанарын ямар үзүүлэлтээр үр дүнгээ хэмжих вэ? Зорилгодоо хүрэхийн тулд хийхээр төлөвлөсөн ажлууд нь хангалттай, тодорхой эсэх
Манлайлан хариуцаж ажиллах оролцогч талтай байх	Өөрчлөлтийг хэн санаачилсан бэ? Тухайн өөрчлөлтийг дэмжих, хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл бусад оролцогч талуудад байна уу? Төсөл хэрэгжүүлэх чадвар чадамж санаачлагчид бий эсэх
Хамтын ажиллагааг дэмжих	Санал болгож буй төсөл нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжиж буй эсэх
Үр ашигтай байх	Шаардлагатай санхүүжилт нь тухай төслийн зорилгод үр ашигтайгаар хүрэхүйц байх

-- МАНАЙ ЗОРИЛТ:

Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар МУ-ын эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах